



#Санхүүгийнзохицуулаххороо

20

Хагас жилийн тайлангийн  
нэгтгэлийн товч танилцуулга

20

Санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч



[WWW.FRC.MN](http://WWW.FRC.MN)



+976-51-264444



[info@frc.mn](mailto:info@frc.mn)

## Оршил

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч болох үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага болон үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаанд хамааруулж зохицуулах, хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлэхээр хуульчлагдсан.




Дээрх чиг үүргийн хүрээнд Хорооны 2020 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн 78 дугаар тогтоолоор Хорооны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж, Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн зохицуулалтын газрыг байгуулсан.

Хорооны зүгээс санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулахад шаардлагатай эрх зүйн орчинг бүрдүүлэхээр дараах журмуудыг баталсан:



### Тохиромжтой этгээдийг тодорхойлох талаар

Хорооны 2020 оны **179** дүгээр тогтоолоор “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ыг баталсан.



Хорооны 2020 оны **182** дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан.

### Тусгай зөвшөөрөл олголт, бүртгэлийн талаарх

Хорооны 2020 оны **120** дугаар тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан.

Хорооны 2020 оны **150** дугаар тогтоолоор “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг баталсан.

### Зайны болон газар дээрх хяналт, шалгалтын талаар


Хорооны 2020 оны **181** дүгээр тогтоолоор “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-ыг баталсан.

## 1. ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН САЛБАР

### 1.1 Өнөөгийн байдал


Дэлхийн ихэнх улс орнуудад үл хөдлөх эд хөрөнгийн салбар нь хөрөнгө оруулалтын чухал салбаруудын нэгд тооцогддог бөгөөд тухайн улсын макро эдийн засаг болоод бодлогын шийдвэр гаргахад чухал нөлөө үзүүлдэг. Манай орны хувьд үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн гараа зах зээлийн эдийн засагт шилжсэн үеэс эхэлсэн гэж үзэж болно. Сүүлийн жилүүдэд үл хөдлөх эд хөрөнгийн зах зээл түүнийг дагасан зуучлалын үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээд нэмэгдэх болсон. Үл хөдлөх эд хөрөнгийн зах зээл нь манай орны дотоодын нийт бүтээгдэхүүний 6 орчим хувийг дунджаар бүрдүүлж байна.

Зураг 1. Үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

“Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ын дагуу тайлант хугацаанд Хороонд нийт **182** хуулийн этгээд хүсэлт ирүүлснээс **103** хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон байна. Үүнээс 2020 оны 4 дүгээр сард нэр бүхий 8 хуулийн этгээдэд, 5 дугаар сард нэр бүхий 53, 6 дугаар сард нэр бүхий 42 хуулийн этгээдэд үл хөдлөх эд хөрөнгийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Нэр бүхий **79** хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг хянаж, журамд заасан шаардлагуудыг бүрэн гүйцэд биелүүлсэн тохиолдолд дахин хянаж үзэх боломжтой талаар албан бичиг хүргүүлсэн.




Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага нь тусгай зөвшөөрлийн хүрээнд 5 үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд 2020 оны эхний хагас жилийн байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон нэр бүхий 103 хуулийн этгээдийг тусгай зөвшөөрлийн төрлөөр ангилсан байдлыг зураг 2-т дүрслэв.

Зураг 2. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагууд үйл ажиллагааны чиглэлээр



Хорооноос тусгай зөвшөөрөл олгосон 103 хуулийн этгээдийн хувьцааг нийт 153 хувьцаа эзэмшигч эзэмшиж байгаа бөгөөд нийт хувьцаа эзэмшигчийн 5 хувь нь хуулийн этгээд байна. Хуулийн этгээдийн эзэмшилд буй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын эцсийн өмчлөгчийг тогтоох, эцсийн өмчлөгчийг тохиромжтой этгээд эсэхийг Хорооны 179 дүгээр тогтоолоор баталсан “Банкнаас бусад санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх тохиромжтой этгээдийг тодорхойлох журам”-ын дагуу хянасан.


Зураг 3. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын хувьцаа эзэмшигчдийн тоо



Тусгай зөвшөөрөлтэй 103 хуулийн этгээд нь 130 брокер, 784 агенттайгаар үйл ажиллагаа эрхлэхээр Хороонд бүртгүүлсэн бөгөөд нэг хуулийн этгээд дунджаар 1 брокер, 7 агенттай ажиллаж байна.

Тусгай зөвшөөрөлтэй үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагуудын 31 нь Сүхбаатар дүүрэгт, 24 нь Хан-Уул дүүрэгт, 20 нь Чингэлтэй дүүрэгт, 17 нь Баянзүрх дүүрэгт, 9 нь Баянгол дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол Дархан-Уул, Орхон аймагт тус бүр 1 хуулийн этгээд үйл ажиллагаа эрхэлж байна.

Зураг 4. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй брокер, агентын тоо



### 1.2 Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын санхүүгийн тайлан

Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын салбарын нэгтгэлд 103 хуулийн этгээд хамрагдсанаас тайлант хугацааны үзүүлэлтээр 83 хуулийн этгээд, эхлэлтийн тайлангаар 20 хуулийн этгээд хамрагдсан. Нийт 153 хувьцаа эзэмшигчийн 1,872,772.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 10,549,182.1 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

Салбарын нийт хөрөнгийн 62 хувь нь эргэлтийн хөрөнгө, 38 хувь эргэлтийн бус хөрөнгө байгаа бол мөнгөн хөрөнгө нийт хөрөнгөнд 21.8 хувийг эзэлж байна. Өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгийн хэмжээнээс 5.7 хувиар илүү байна. Тус салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн 67 хувь нь олон улсын франчайзийн эрхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын санхүүгийн байдлын тайлан. /мянган төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,303,725.10
Дансны авлага	1,532,819.72
Татвар, НДШ – ийн авлага	27,779.26
Бусад авлага	179,348.81
Бараа материал	1,753,875.40
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	608,440.15
Бусад эргэлтийн хөрөнгө	134,412.70
Эргэлтийн хөрөнгийн дүн	6,540,401.15
Үндсэн хөрөнгө	3,156,629.33
Биет бус хөрөнгө	745,823.16
Урт хугацаат хөрөнгө оруулалт	106,328.50
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,008,780.98
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>10,549,182.13</b>
Дансны өглөг	5,605,281.76
Цалингийн өглөг, татварын өр, НДШ-ийн өглөг	982,265.79
Банкны богино хугацаат зээл	505,412.40
Хүүний өглөг, Ногдол ашгийн өглөг	364,536.09
Урьдчилж орсон орлого	1,569,445.62
Бусад богино хугацаат өр төлбөр	771,122.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн	9,878,325.36
Урт хугацаат зээл, бусад урт хугацаат өр төлбөр	1,278,484.99

Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,282,106.09
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>11,160,431.45</b>
Өмч	1,872,772.00
- хувийн	1,872,772.00
Нэмж төлөгдсөн капитал	12,530.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	56,652.00
Эздийн өмчийн бусад хэсэг	197,462.31
Хуримтлагдсан ашиг	-2,750,669.74
Эздийн өмчийн дүн	-611,249.33
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	10,549,182.12

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй 103 хуулийн этгээд 17,367,921.3 мянган төгрөгтэй тэмцэх хэмжээний борлуулалтын орлого, 2,322,629.4 мянган төгрөгтэй тэмцэх хэмжээний түрээсийн орлоготой ажилласан. Нийт зардлын 56.1 хувийг ерөнхий болон удирдлагын зардал, 0.08 хувийг борлуулалт, маркетингийн зардал бүрдүүлж байна. Тайлант хугацаанд нийт 352,423.2 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан.

Хүснэгт 2. Борлуулалтын орлогын тайлан /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Нийт
Нийт орлого	19,727,533.0
Борлуулалтын орлого (цэвэр)	17,367,921.30
Түрээсийн орлого	2,322,629.44
Хүүний орлого	6,637.74
Бусад орлого	43,619.95
Нийт зардал	19,350,000.0
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,713,658.26
Борлуулалт, маркетингийн зардал	1,619,246.08
Ерөнхий ба удирдлагын зардал	10,871,880.92
Санхүүгийн зардал	67,665.50
Бусад зардал	22,185.89
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-3,899.92
Тайлант үеийн цэвэр ашиг	352,423.17


Зураг 5. Санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтээс /мянган төгрөгөөр/



### 1.3 Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын сарын мэдээ


Нэр бүхий 37 хуулийн этгээд 2020 оны 6 дугаар сард үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйлчилгээг эрхэлсэн бөгөөд нийт 49,226,098.6 мянган төгрөгтэй тэмцэх хэмжээний үл хөдлөх эд хөрөнгийг борлуулах хэлцэл хийсэн. Тайлант хугацаанд нийт 399 хэлцлээр үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах үйлчилгээг үзүүлсэн. Үүнээс Хан-Уул дүүрэгт хамгийн олон борлуулалтыг буюу 158 гэрээ хэлцлийг хийж гүйцэтгэсэн бол алслагдсан гурван дүүрэгт үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаар дамжуулан үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан тохиолдол гараагүй байна.

Хүснэгт 3. Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах, шилжүүлэх үйлчилгээ




Чингэлтэй дүүрэгт 1 м.кв байрны үнэ 3,576.9 мянган төгрөг буюу хамгийн өндөр үнэтэйгээр борлуулагдсан бол Сонгино хайрхан дүүрэгт 1 м.кв байрны үнэ хамгийн хямд буюу 1,610.9 мянган төгрөгний үнэтэйгээр борлуулагдсан байна. /Зураг 6/

Зураг 6. Улаанбаатар хотод борлуулагдсан үл хөдлөх эд хөрөнгийн үнэ дүүргээр



Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйлчилгээг нэр бүхий 25 хуулийн этгээд эрхэлсэн бөгөөд 2,003,965.4 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 185 гэрээ хэлцлийг хийж гүйцэтгэснээс Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт тус бүр 50 гэрээ хэлцэл, Хан-Уул дүүрэгт 47, Баянгол дүүрэгт 22, Чингэлтэй дүүрэгт 14, Сонгино хайрхан дүүрэгт 1 гэрээ хэлцэл хийгдсэн байна. Нийт харилцагчийн 136 нь түрээслэх, 49 нь түрээслүүлэх гэрээ байгуулжээ.

Зураг 7. Үл хөдлөх эд хөрөнгийн зуучлалын байгууллагын үйлчилгээ үзүүлсний төлбөр




Үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг түрээслэх, түрээслүүлэх, хөлслөх, хөлслүүлэх үйлчилгээ үзүүлсний төлбөрийн шимтгэл нь 63% байна. Учир нь нэг удаагийн түрээсийн төлбөрийг үзүүлсэн үйлчилгээний эхэнд ихэвчлэн авдаг тул үнийн дүнтэй харьцуулахад өндөр гардаг байна. Харин үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрхийг худалдах, худалдан авах үйлчилгээ үзүүлсний төлбөр дунджаар 3% байна.

#### 1.4 Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх /МУТС/ эрсдэлийн үнэлгээ

Тайлант хугацаанд Хорооны 181 дүгээр тогтоолоор баталсан “Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-д заасны дагуу комплаенсын эрсдэлийн үнэлгээний тайлан, бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний тайланг нэр бүхий 86 хуулийн этгээдээс ирүүлсэн.

Зураг 8. МУТС эрсдэлийн үнэлгээг боловсруулах аргачлалын талаар



МУТС эрсдэлийн үнэлгээг Олон улсын валютын сангийн аргачлалын дагуу үнэлэх бөгөөд үнэлгээний зарим хувьсагчийг шинээр зохицуулалтад орж буй байгууллагын хувьд үнэлэх боломжгүй тул хувьсагчийг төлөөлүүлж болохуйц хувьсагчаар орлуулан үнэлгээг боловсруулсан. Эрсдэлийн үнэлгээг боловсруулахдаа бизнесийн болон бүтцийн эрсдэлийн үнэлгээний хувийн жинг 30 хувиар, комплаенсын эрсдэлийн үнэлгээг 40 хувиар жигнэж тооцсон.

Хүснэгт 4. МУТС эрсдэлийн үнэлгээний үр дүн

	Эрсдэл бага	Дундаж	Эрсдэлтэй	Үнэлэх боломжгүй
Эрсдэл бага	20			
Дундаж		64		
Эрсдэлтэй			2	
Үнэлэх боломжгүй				17


МУТС эрсдэлийн үнэлгээний тайлангаас харахад тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн 20 нь эрсдэл бага гэж үнэлэгдсэн бол 64 хуулийн этгээд дундаж эрсдэлтэй гэж үнэлэгдсэн. МУТС дундаж эрсдэлтэй гэж үнэлэгдсэн нэр бүхий 64 хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээ дундаж гарсан шалтгаан нь комплаенсын эрсдэлийн оноо өндөр гарсантай холбоотой байна. Тайлант хугацаанд дээрх байгууллагууд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргийн дагуу дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөрийг боловсруулсан хэдий ч хэрэгжүүлж ажиллах, хуульд заасан үүргээ хэрэгжүүлэхэд цаг хугацаа хэрэгтэй байгаа нь ажиглагдаж байна. МУТС эрсдэлийн үнэлгээний тайланд эрсдэлтэй гэж нэр бүхий 2 хуулийн этгээд үнэлэгджээ. Эрсдэлийн түвшин өндөр гэж үнэлэгдсэн дээрх 2 байгууллагын эрсдэлийн үнэлгээний задаргааг харахад комплаенсын эрсдэлийн үнэлгээг 2-2.1 гэж үнэлсэн нь ихээр нөлөөлсөн. Бүтцийн болон бизнесийн эрсдэлийн үнэлгээг 1.5-1.9 хооронд үнэлсэн байна. Нэр бүхий 17 хуулийн этгээдийн хувьд үнэлгээнд шаардлагатай тайлан мэдээг бүрэн гүйцэд ирүүлээгүй тул үнэлэх боломжгүй төлөвд багтсан. Учир нь эрсдэлийн үнэлгээний аль нэг хэсгийг ирүүлээгүй тохиолдолд эрсдэлийн үнэлгээг боловсруулах боломжгүй болгодог.

## 2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нар

### 2.1 Тусгай зөвшөөрөл олгогдсон байдал

Хорооны 150 дугаар тогтоолоор батлагдсан “үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ыг баталснаас хойш хагас жилийн байдлаар Хороонд нийт **31** хуулийн этгээд хүсэлт ирүүлснээс **8** хуулийн этгээдэд, **307** иргэн хүсэлт ирүүлснээс **267** иргэнд тусгай зөвшөөрөл олгосон байна. Хороо 5 дугаар сард 36 иргэн, 2 хуулийн этгээдэд, 6 сард 231 иргэн, 6 хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл тус тус олгосон.


*Зураг 9. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн арилжаа эрхлэгчдийн тоо.*



“Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-д зааснаар 3

төрлийн үйл ажиллагааг эрхлэх боломжтойгоор журамлагдсан. Хагас жилийн байдлаар үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 267 иргэнд тусгай зөвшөөрөл олгосноос 153 нь үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, 71 нь үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч, 43 нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч байна. Мөн Хорооноос 8 хуулийн этгээдэд үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос 5 нь үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч бол 3 нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч байна.

Зураг 10. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийн ангилал







Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 8 хуулийн этгээд 100 хувь нэгтгэлд хамрагдсан бөгөөд 12 хувьцаа эзэмшигчийн 3,463,622.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгө, 8,073,760.3 мянган төгрөгийн нийт хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж байна.

## 2.2 Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн санхүүгийн тайлан.

Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 8 хуулийн этгээд санхүүгийн тайлан мэдээгээ Хороонд хүргүүлсэн. Дээрх 8 хуулийн этгээдийн борлуулалтын орлого тайлант хугацаанд 607,394.3 мянган төгрөг байсан бол нийт ашиг 378,184,3.0 мянган төгрөгтэй тэнцэж байна. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн нийт хөрөнгийн хэмжээ 8,073,760.0 мянган төгрөг байна. Салбарын нийт хөрөнгийн 51.4 хувийг эргэлтийн хөрөнгө, 48.6 хувийг эргэлтийн бус хөрөнгийн дүн эзэлж байгаа бол өр төлбөрийн хэмжээ нийт хөрөнгийн хэмжээнээс 11.3 хувиар илүү байна.

Хүснэгт 5. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн санхүүгийн байдлын тайлан /мянган төгрөг, хувиар/

ҮЗҮҮЛЭЛТ	Нийт	Нийт хөрөнгөд эзлэх хувь	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	596,488.4	7.4%	 <p>Нийт хөрөнгө</p> <p><b>8,073,760.0</b></p>
Дансны авлага	1,656,083.9	20.5%	
Бусад авлага	620,000.0	7.7%	
Бусад санхүүгийн хөрөнгө	77,906.8	1.0%	
Бараа материал	1,115,481.7	13.8%	
Урьдчилж төлсөн зардал/гооцоо	81,882.3	1.0%	
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>4,152,165.5</b>	<b>51.4%</b>	
Үндсэн хөрөнгө	3,871,399.0	48.0%	 <p>Эздийн өмч</p> <p><b>3,463,622.0</b></p>
Урт хугацаат хөрөнгө оруулалт	46,376.6	0.6%	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,921,594.7	48.6%	
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>8,073,760.2</b>	<b>100.0%</b>	
Дансны өглөг	3,098,844.5	38.4%	
Цалингийн өглөг	11,925.2	0.1%	
Татварын өр	292,567.1	3.6%	
НДШ - ийн өглөг	15,603.5	0.2%	 <p>Борлуулалтын орлого</p> <p><b>607,394.3</b></p>
Банкны богино хугацаат зээл	3,477,610.5	43.1%	
Хүүний өглөг	785,848.4	9.7%	
Бусад богино хугацаат өр төлбөр	951,236.2	11.8%	
Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,634,015.4	106.9%	
Урт хугацаат зээл	349,029.8	4.3%	
Урт хугацаат өр төлбөрийн дүн	349,029.8	4.3%	
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>8,983,045.2</b>	<b>111.3%</b>	
Өмч	3,463,622.0	42.9%	 <p>Хуримтлагдсан ашиг</p> <p><b>-4,753,499.55</b></p>
- хувийн	3,463,622.0	42.9%	
Эздийн өмчийн бусад хэсэг	380,592.6	4.7%	
Хуримтлагдсан ашиг	-4,753,499.5	-58.9%	
Эздийн өмчийн дүн	-909,284.9	-11.3%	
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>8,073,760.2</b>	<b>100.0%</b>	

Тайлант хугацаанд нийт 809,377.9 мянган төгрөгийн орлого олж, 2,078,919.5 мянган төгрөгийн зардалтайгаар үйл ажиллагаа явуулсан байна. Нийт орлогын 75 хувийг борлуулалтын орлого, 20.5 хувийг түрээсийн орлого бүрдүүлж байна. Нийт зардлын 46.5 хувийг борлуулалт, маркетингийн зардал, 39.1 хувийг ерөнхий ба удирдлагын зардал эзэлж байна. Хагас жилийн байдлаар 1,290,817.7 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Хүснэгт 6. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн тайлант хугацаан дахь орлогын тайлан /мянган төгрөг, хувиар/

Үзүүлэлт	НИЙТ	Хувиар
Нийт орлого	809,377.9	100%
Борлуулалтын орлого (цэвэр)	607,394.3	75%
Түрээсийн орлого	165,960.0	20.5%
Хүүний орлого	27,055.70	3.3%
Бусад орлого	8,967.9	1.1%
Нийт зардал	2,078,919.5	100%
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	229,210.0	10.9%

Борлуулалт, маркетингийн зардал	977,303.2	46.5%
Ерөнхий ба удирдлагын зардал	820,787.5	39.1%
Санхүүгийн зардал	32,390.0	1.5%
Бусад зардал	29,768.9	1.4%
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-10,530.1	0.5%
Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)	-1,290,817.7	

### 2.3 Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн МУТС эрсдэлийн үнэлгээ

Хорооны 2020 оны 182 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам”-д тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь улирал тутам болон хагас жилд МУТС эрсдэлийн үнэлгээний тайланг ирүүлэхээр зохицуулсан. Тайлант хугацаанд тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 8 хуулийн этгээд МУТС эрсдэлийн үнэлгээний тайланг ирүүлсэнд үндэслэн эрсдэлийн үнэлгээг боловсруулсан.

*Хүснэгт 7. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн МУТС эрсдэлийн үнэлгээний матриц*

	Эрсдэл бага	Дундаж	Эрсдэлтэй	Үнэлэх боломжгүй
Эрсдэл бага	2.0			
Дундаж		5.0		
Эрсдэлтэй			0.0	
Үнэлэх боломжгүй				1.0

МУТС эрсдэлтэй хуулийн этгээд байхгүй гэж үнэлэгдсэн бол 5 нь дундаж эрсдэлтэй 2 нь эрсдэл багатай гэж үнэлэгдсэн. Дундаж эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 5 хуулийн этгээдийн эрсдэлийн үнэлгээнд комплаенсын эрсдэлийн үнэлгээ болон бүтцийн эрсдэлийн үнэлгээ ихээр нөлөөлсөн. МУТС тухай хуульд заасан дотоод хяналтын болон эрсдэлийн үнэлгээний хөтөлбөрийг боловсруулсан хэдий ч үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах тал дээр дутмаг байгаа нь харагдаж байна. Цаашид тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээд бүрийн хувьд МУТС эрсдэлийн үнэлгээг улирал бүр үнэлэх нөхцөл бүрдсэн.

### 2.4 Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн сар бүр ирүүлэх тайлан мэдээний хураангуй

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 11 иргэн 867.5 кг үнэт металл /810.8 кг алт, 56 кг мөнгө, 0.096 кг платин/-ыг 110,719,961.7 мянган төгрөгөөр худалдаж авсан бол 882.9 кг үнэт металл /879.7 кг алт, 3.2 кг мөнгө/-ыг 125,355,969.7 мянган төгрөгөөр худалдсан байна.

## ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛ, ҮНЭТ ЭДЛЭЛ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР